



Сургуулийн насны хүүхдүүд заавал сургуульд хамрагдах ёстой

Эцэг эх, асран хамгаалагчид зориулсан мэдээлэл

Таны хүүхдийн боловсрол эзэмших асуудал нь маш чухал бөгөөд сургуульд тогтмол хамрагдах нь таны хүүхэд хамгийн сайнаар боловсрол эзэмшиж, ажил мэргэжил болон амьдралдаа илүү сонголттой болоход чухал үүрэгтэй юм. NSW мужийн сургуулиуд эцэг эхчүүдтэй хамтран хүүхэд, өсвөр үеийнхний сургуулийн тогтмол ирцийг дэмжих зорилгоор ажилладаг. Таны хүүхэд өдөр бүр сургуульдаа ирж суралцсанаар түүний суралцах явц илүү хялбар болж, бусад хүүхдүүдтэй үерхэн нөхөрлөх болно.

Хуулийн дагуу би ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Шинэ Өмнөд Уэльс мужид 6-аас 17 насны бүх хүүхэд боловсрол эзэмших ёстой байдаг. 1990 оны Боловсролын тухай хуулиар эцэг эхчүүд заавал сургуулийн насны хүүхдээ сургуульд элсүүлэх, сургуульд тогтмол хамруулах, эсвэл NSW мужийн Боловсрол, Стандартын Газарт гэрээр сургах хөтөлбөрт бүртгүүлсэн байхыг шаарддаг.

Сургуульд элссэний дараа хүүхдүүд өдөр бүр сургуульдаа явах шаардлагатай.

Сургуульд цагтаа ирэхийн ач холбогдол

Таны хүүхэд сургуульд цагтаа ирсэнээр:

- тухайн өдөр эрт төлөвлөгдсөн сургалтын чухал үйл арга хэмжээнүүдэд оролцоно
- сурагчдад цаг баримтлах, хэвшүүлэхийн ач холбогдлыг ойлгоход тусална
- сурагчид хичээл эхлэхээс өмнө найзуудтайгаа мэндлэх, харилцах цаг гаргаж өгнө
- хичээлийн тасалдлыг багасгана.

Хичээлээс хоцрохыг хэсэгчилсэн таслалт гэж бүртгэдэг бөгөөд эцэг эхчүүд үүнд тайлбар өгөх ёстой байдаг.

Хэрэв миний хүүхэд сургуулиас хол байгаа бол яах вэ?

Зарим тохиолдолд таны хүүхэд хичээлдээ явахгүй байх шаардлага гарч болдог. Сурагчийг дараах шалтгаанаар хичээлд ирээгүй бол үндэслэлтэй шалтгаан гэж үзэж болно:

- Өвчтэй, эсвэл халдварт өвчтэй байх
- зайлшгүй шаардлагатай эмнэлгийн үзлэгт хамрагдах
- хүлээн зөвшөөрөгдсөн шашны зан үйл, баяр, амрах шаардлагатай байх
- гэр бүлийн онцгой эсвэл яаралтай нөхцөл байдал үүсэх, жишээ нь: оршуулах ёслолд оролцох

Хүүхэд сургуулиас завсардсаны дараа та 7 хоногийн дотор хүүхдийнхээ сургуульд хичээл тасалсан тухай амаар болон бичгээр тайлбар өгөх ёстой. Харин 2 хоногийн дотор таны зүгээс тайлбар ирүүлээгүй тохиолдолд сургууль тантай холбогдож энэ талаар ярилцах болно.

Хичээл таслалт нь таны хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй байна гэж үзвэл сургуулийн захирал таны өгсөн тайлбарыг хүлээн авахаас татгалзаж болно. Ийм нөхцөлд таны хүүхэд үндэслэлгүйгээр хичээл тасалсан гэж бүртгэгдэх болно. Ингэсэн тохиолдолд захирал тантай уг шийдвэрийн талаар ярилцах болно.

Байн байн болон удаан хугацаагаар хичээл тасалсаныг өвчний улмаас гэж тайлбарласан тохиолдолд захирал эмчийн бичиг болон бусад бичиг баримтыг шаардаж болно. Захирал мөн эцэг эхийн зөвшөөрөлтэйгөөр уг хүүхдийн эрүүл мэндийн байдалд шаардлагатай тусламж үзүүлэх төлөвлөгөөг хамтран боловсруулахын тулд эмнэлгийн мэргэжилтнүүдтэй холбогдон ярилцаж болно. Хэрэв уг хүсэлтийг эцэг эх хүлээн авахаас татгалзвал сургуулийн захирал үндэслэлгүй таслалт гэж тэмдэглэж болно.

Аялах

Сургуулийн амралтын үеэр гэр бүлээрээ аялах явдлыг бид дэмждэг. Харин сургуулийн хичээлийн үеэр аялах шаардлагатай бол энэ талаар сургуулийн захиралтай ярилцаарай. Мөн урт хугацааны чөлөө авах өргөдлийг бөглөх шаардлагатай болж магадгүй. Аялал жуулчлалтай холбоотой чөлөөг таслалт гэж тооцдог тул тухайн сурагчийн бүтэн жилийн хугацаанд тасалсан өдөрт тооцогддог.

Зарим тохиолдолд сурагчид хичээлийн 50-аас дээш хоногийн хугацаанд зайны сургалтанд хамрагдах боломжтой байдаг бөгөөд энэ талаар хүүхдийнхээ сургуулийн захиралтай ярилцах хэрэгтэй.

Миний хүүхэд сургуульд явахгүй байна, би яах ёстой вэ?

Та аль болох хурдан захиралтай холбогдон уг асуудлыг ярилцаж, тусламж хүсэх хэрэгтэй. Сурагчийн ирцийг сайжруулахад туслах стратеги нь сургуулийн Суралцах явцыг дэмжих багт шилжүүлэх эсвэл хүүхдийг зохих дэмжлэг үзүүлэгч байгууллагуудтай холбох зэрэг байж болно. Захирал уг сурагчийн Ирцийг сайжруулах төлөвлөгөө боловсруулах зорилгоор Гэрээс суралцах хөтөлбөрөөс нэмэлт дэмжлэг хүсч болно.

Хэрвээ миний хүүхэд хүлээн зөвшөөрөгдөхгүй шалтгаанаар хичээл тасалсан хэвээр байвал юу болох вэ?

Сургуулийн насны хүүхдүүд шалтгаангүй, үндэслэлгүйгээр хичээл таслах тохиолдол байнга гаргаж байгаа бол Боловсролын яамнаас арга хэмжээг үргэлжлүүлэн авах шаардлага гарч болохыг эцэг эхчүүл ойлгох нь чухал юм.

Дараах арга хэмжээг авч болно:

- Сургуульд заавал суралцуулах хурал

Сургуульд заавал суралцуулах хуралд оролцохыг та болон таны хүүхдээс хүсч магадгүй. Уг хурал нь таны хүүхэд сургуульд тогтмол хамрагдахын тулд түүнд ямар дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг тодорхойлох зорилготой. Сургууль, эцэг эх, болон холбогдох агентлагууд таны хүүхдийг сургуульд суралцахад нь дэмжлэг үзүүлэхийн тулд төлөвлөгөөг (Үүрэг гэж нэрлэдэг) боловсруулахын тулд хамтран ажиллана.

- Хүүхдийн шүүхэд өргөдөл гаргах - Сургуульд заавал суралцуулах тушаал

Хэрэв таны хүүхдийн хичээлийн ирц хангалтгүй хэвээр байвал тус яам нь Хүүхдийн шүүхэд хандаж заавал сургуульд сургах шийдвэр гаргуулахыг хүсч болно. Хүүхдийн шүүхийн шүүгчийн зүгээс Сургуулийн заавал суралцуулах хурлыг хийлгэх шийдвэр гаргаж болно.

- Орон нутгийн шүүхээр шийдвэр гаргуулах ажиллагаа

Сургууль болон яамны ажилтнууд таны хүүхдийг сургуульд бүрэн хамрагдахад саад болж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд тантай хамтран ажиллах үүрэг хүлээсэн хэвээр байна. Сургуульд заавал суралцах журмыг зөрчсөн тохиолдолд эцэг эхийн эсрэг орон нутгийн шүүхэд хандан арга хэмжээ авахуулах өргөдөл гаргаж болно. Шүүхээс олон нийтийн ажил хийлгэх, торгууль оноох шийдвэр гарч болно.

Миний хүүхэд хэдэн насандаа сургуулиа орхиж болох вэ?

Шинэ Өмнөд Уэльсийн бүх сурагчид 10-р анги, эсвэл түүнтэй дүйцэхүйц ангид суралцаж төгссөн байх ёстой. 10-р ангиас хойш, 17 нас хүртлээ сурагчид сургуулиа дүүргэх уян хатан сонголтуудыг бид санал болгодог.

Хамтын ажиллагаа

Сурагчид болон тэдний гэр бүлтэй хамтран ажиллах нь сурагчдыг сургууль хичээлдээ тогтмол хамрагдахад туслах хамгийн сайн арга гэдгийг NSW-ийн Боловсролын яам хүлээн зөвшөөрдөг.

Таны хүүхэд өөрийнхөө ирээдүйн боломжит зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлэхэд бид тантай хамтран ажиллахдаа баяртай байх болно.

Орчуулгын үйлчилгээ

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургуультай холбогдоно уу. Сургуультай холбогдохын тулд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол 131 450 дугаарт холбогдож, ямар хэлний орчуулагч хэрэгтэйг хэлж, оператороос сургуультай холбож өгөхийг хүснэ үү. Оператор таны ярианд туслах зорилгоор орчуулагчтай холбож өгөх бөгөөд уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.